

ТӨВ ҮЗЛИЙН ШАСТАР НЯГТАД ЭЭРЭМДЭГЧИЙН ТАЙЛБАР, УХААРАХУЙ ЁСТ АЛТАН ХҮРДЭН ОРШИВОЙ

(dBu ma'i bstan bcos zhib mo rnam 'thag gi 'grel pa rigs tshul
gser gyi 'hor lo zhes bya ba bzhugs so)

Төвд хэлнээс орчуулсан С. Янжинсүрэн - МУИС. НШУС. Шашин Судлалын тэнхим,
доктор

Гүрү Дэва Ринбүчи 1975 онд Заваа Дамдин /1867-1937/ гавжийн бүрэн сүнбүмийг Энэтхэгт 17 боть болгон хэвлүүлснээс nga ботийн 471-487 дахь талд эл зохиол төвд эхээрээ буйгаас авч орчуулав.

472. Зоригдол үгүй нигүүлсэхүй сэтгэлийн эзэн лам хийгээд Богдын өлмий дор мөргөмүү.

Утга гүнзгий судар номыг өгүүлэхийн ухаантны шавь, буяны давалгаа түүн дор мөргөмүү.

Хутагт багш Лүдэв бээр зохиосон төв үзлийн шастар Нягтад тээрэмдэгчийн үгийн утгыг ухаарахад хялбаршуулан номлохуй дор гурав болой. Нэрийн утга, номын утга, төгсгөлийн утга болой.

Анхдугаарх нь: Энэтхэгийн хэлээр шастар түүний нэр дор Ведалясүгшамэсутранама, тэр нь төвдийн хэлээр Шивмонамбартагва хэмээмүй. Бас тэр ведаля нь сайтар тээрэмдэгч, сүгшамэ нь нягт нарийн, сутра нь судар, нама нь хэмээгч болой. Утга нь:

Багштаны төв үзлийн ухааны чуулган бусдыг өөрийн хийгээд бусдын аймаг өвөрмөц өгүүлэгч нүгүүд бээр ам авсан бүтээгдэхүүнийг үнэн бодитой, нийт хийгээд ялгамжаатай дор хаах ёс, тэмцлийг тэвчих лугаа сэлт дор номлосон. Энэ ном түүний бүтээгч нь нягт атгагийн үг утга арванзургааг өгүүлэгчдийг ухаанаар сайтар тээрэмдэн зохиосон болой. Хоёрдугаарт хоёр. Шастарыг зохиосны хэрэг хийгээд хэрэг түүн лүгээ төгссөний шастарын бодитыг гаргана. Анхдугаарх нь, шинжлэл тэргүүлэх болой. Утга нь, шинжлэлтнүүдийн ухаарсныг нягтад хүсээд сайтар тээрэмдэхийн тулд шастар үүнийг номлон үйлдэхэд хэрэг буй бөлгөө. Шинжлэлтний үг утга арванзургаа хэмээхийн омгийг өвөрмөц өгүүлэгч алин нугууд төв үзэлтэнд тэмцэхийг илт хүсэгч түүний омгийг дарахын тухайд мөний тул. Хоёрдугаарт гурав. Шинжлэлтний таалан хэлдэг түүнийг хааж, түүнд тэмцлийг тэвчих болой. Анхдугаарх нь, зарим нэгэн, бодит нугууд өвөрчлөнгөөр бүтсэн болой. Бодит өвөрчлөнгөөр үгүйн зүгт шинжлэлтний үг утга арванзургаа

473. үгүйн тул болой. Түүн дор арванзургаа буй. Шалгадаг мэдэл, үлигдэхүүн, сэжиг, хэрэг, үлгэр, тогтсон таалал, гишүүн, шинжлэл, нотлон шийдэх, тэмцэл, өгүүлэх, шүүн эсэргүүцэх, засдаг учир шалтгаан, үгсийг ороох, хэтрүүлэх, гэсгээх нугууд буйн тул болой хэмээн өгүүлсэн болой.

Хоёрдугаарт, арванзургаагаас анхдугаарх шалгадаг мэдэл хийгээд хоёрдугаарх улигдэхүүн хоёрыг нэгэн зүгт шижлэхүйд гурав. Шалгадаг мэдэл хийгээд улигдэхүүн холилдсоноор хамаарсныг хаах. Урьд хожид дор шинжээд хамаарсныг хаах. Илт мэдлийн орлого өвөрчлөнгөөр бүтсэнийг хаах болой. Анхдугаарт, бодит хийгээд түүний гэм тэвчхийг хаахад хоёр. Анхдугаарх нь, шалгадаг мэдэл тэргүүтэн болой. Утга нь, шалгадаг мэдэл хийгээд улигдэхүүн нүгүүд нь хоёул холилдсон бөгөөд харгалзсан мөн. Шалгадаг мэдлээр улигдсэнийг улигдэхүүн, улигдэхүүн улигдснээр шалгадаг мэдэл бүтдэгийн тул. Утга нь, тэр нь өөрийн мөн чанараас мөн чанараар бүтсэн бус болой, хамаарснаас бүтсэний тул болой. Мөн чанараар буй хийгээд огтоос үгүй хийгээд тэр хоёр хоёулын бодит нугуудад нь хамаарагч үл зохихын тул болой. Хоёрдугаарх нь, бус тэргүүтэн болой. Утга нь, зарим нэгэн, хэмжигч жин үгүй бол түүний улигдэхүүн ч үгүй. Тэрчлэн хэмжигч үйлдэх шалгадаг мэдэл үгүй учир түүний улигдэхүүн ч үгүй. Шалгадаг мэдлээс өөрөөс нь өөр утгатай хэмжигч шалгадаг мэдэл мөн чанараар буй болой хэмээвээс. Шалгадаг мэдэлд хэмжин үйлдэгч шалгадаг мэдэл мөн чанараар буй нь бус буюу. Тэр буй аваас улигдэхүүн хязгааргүй болохын тул. Зарим нэгэн, шалгадаг мэдлүүдэд өөрөөс өөр утгатай хэмжигч шалгадаг мэдэл үгүй буюу. Зулчлан шалгадаг мэдлүүд нь өөр хийгээд бусдад үйлдэн үйлдэгчийн тул хэмээвээс.

474. Шалгадаг мэдэлд өөрөөс бусад утгатай хэмжигч шалгадаг мэдэл үгүй аваас шалгадаг мэдлээр өөр, бус хоёулыг бүтээн үйлдэх зохисгүй болой. Зул нь харанхуй лугаа учрах хийгээд эс учрах ч харанхуйг мөн чанараар арилгаж эс зохихын тул. Зарим нэгэн, зул хийгээд харанхуй эс учирсан ч гарагийн хорчлон утгынхаа үесэд ч арилгагдахуун хийгээд арилгагч болох болой хэмээвээс. Тэр ч бус буюу. Гарагийн хор хийгээд зул бээр харанхуйг арилгах хоёрын утга харшлахын тул болой. Шастарт алдаршсан хийгээд ертөнцийг эдлэх ёс түүнд ч арслан тэргүүтэн Ванчүг, Цанба тэргүүтний ном адил үлгэрийг авах нь таалал мөн. Ном эс зохилдуу үлгэрийг үл таалахын тул. Зул нь өөрөө өөр ямагтаа гийлүүлэгч бус, өөрийн нь халхалсан харанхуй үгүйн тул. Түүнээс бусдад харанхуй ч өөрөө өөр ямагтаа халхлах болж хэтэрмүй. Зул бээр өөрийгөө гийгүүлэхийн тул. Таалал тань таарахгүй буюу. Харанхуй нүхэнд харанхуй үл үзэгдэх тэргүүтэн чанх бурууд хэтрэх болохын тул. Хоёрдугаарх, урьд хождод шинжлээд хамаарахыг хорих хоёр буй. Бодит хийгээд түүний гэм тэвчсэнийг хаах болой. Анхдугаарх нь, шалгадаг мэдэл тэргүүлэх буюу. Утга нь, шалгадаг мэдэл хийгээд улигдэхүүнүүд нь мөн чанараар үгүй учир урьд хожид хийгээд хамт нэгэн гарсан гурван цагийн алинд ч мөн чанараар эс бүтсэний тул. Хоёрдугаарх нь, гурван цаг тэргүүлэх буюу. Утга нь, зарим нэгэн, шалгадаг мэдэл хийгээд улигдэхүүнийг хорих хаагч үл зохих учир гурван цагт хаагч шалгадаг мэдэл хийгээд улигдэхүүнүүд мөн чанараар эс бүтсэний тул болой. Тиймээс хаагдахуун шалгадаг мэдэл хийгээд улигдэхүүнүүд мөн чанараар үгүй аваас түүнийг хорих хаагч ч үгүй хэмээвээс. Хаагч бүтвээс хаагдахуун шалгадаг мэдэл хийгээд улигдэхүүн

475. ч мөн чанараар бүтсэн хэмээн өгүүлэх нь бус болой. Хаагдахуун шалгадаг мэдэл хийгээд улигдэхүүн мөн чанараар бүтсэнийг хорих хаагч чи өөрөө урьд тэр даруй дөнгөж сая ам авсны тул болой. Хэрэв шалгадаг мэдэл хийгээд улигдэхүүн нүгүүд гурван цагт мөн чанараар эс бүтэхүйд ам авсан тул түүнийг хорих хаагч хийгээд хорьж үйлдэх үг ч эс бүтэхүйд таалах хэрэгтэй мөн гэх нь зохисгүй. Хоригдохуун шалгадаг мэдэл хийгээд улигдэхүүн мөн чанараар бүтсэнийг хорих хаагч ам авах лугаа цаг чацуу зарим нэгний тэмцэлдэн өгүүлэх нь тэмцлээс одсон мөний тул. Хаагдахуун мөн чанараар эс бүтвээс хаагч эс бүтэх хэрэгтэй учир шалгадаг мэдэл хийгээд улигдэхүүн мөн чанараар эс

бүтэхүйд тэр мэт бүтээн баригч атгагийг тэвчхэд мөний тул. Гуравдугаарх, илт мэдлийн орогдохуун мөн чанараар бүтсэнийг хориход хоёр болой. Бодит хийгээд түүний гэм тэвчсэнийг хаах болой. Анхдугаарт хоёр болой. Зүг урд хийгээд хариу болой. Анхдугаарх нь, илт тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, илт хийгээд даган үлих тэргүүтний шалгадаг мэдэл нь буй мөн болой. Тэдгээр нүгүүд бээр өөрийн үлигдэхүүнд ч тэдгээрт оносны тул хэмээвээс. Хоёрдугаарх нь илт тэргүүлэх буюу. Утга нь илт, шалгадаг мэдэл тэргүүтэн бүтсэн ч үлигдэхүүн болдог бумба мэт нь шалгадаг мэдэл илтийн үлигдэхүүн мөн чанараар бүтэхүйд зохисгүй буюу. Тэр өөрөө илт мөний тул. Тэрчлэн далд бологчууд ч даган үлихийн үлигдэхүүн мөн чанараар үгүй буюу. Гал хийгээд утаа тэргүүтний шинж хийгээд шинжтэний барилдлагаас гарсан илтийг урьд нь одогчийн үүднээс даган үлих гэж өгүүлж байгаа мөний

476. тул. Хоёрдугаарх, түүний гэм тэвчсэнийг хаах нь түүний нөхцөл тэргүүлэх буюу. Утга нь, Ригважан нэгэн, бумбыг барьсан оюун нь шалгадаг мэдэл хийгээд бумба нь үлигдэхүүн мөн учир гэм үгүй болой, хэмээвээс. Бумбыг барьсан оюун нь мэдэл ч биш адил бумба тэр бээр мэдэгдэхүүн ч бус буюу. Бумба тэр нөхцөлт ямагт болох мөний тул хэмээвээс. Эрхтэний утга учрахгүйн тул. Үлгэрлэвээс эрхтэн адил. Бумбыг баригч оюун нь эрхтэний утга учирснаас гарсан шалгадаг мэдэл бус. Үлигдэхүүн мөнд илтэд өгүүлэхийн тул. Үлгэрлэвээс би хийгээд бие тэргүүтэн адил болой. Гуравдугаарх, сэжгийг хаахад хоёр болой. Бодит хийгээд гэм тэвчсэнийг хаах болой. Анхдугаарх нь, зүг урдахь нэгэн, шалгадаг мэдэл хийгээд үлигдэхүүнүүд нь үнэхээр бүтсэн болой. Тэр мэт бүтсэн эсвэл эс бүтсэн гэхийн сэжиг мөн чанараар бүтсэний тул. Зоригдол үгүйн утгад сэжиг орохгүйн тул хэмээвээс. Зоригдол буюу зоригдол бусын утгуудад сэжиг мөн чанараар үгүй буюу. Зоригдол нь буй, зоригдол бус нь үгүй ямагтын тул болой. Хоёрдугаарх нь, сэжиг тэргүүлэх буюу. Утга нь, зарим нэгэн, сэжиг нь буй мөн болой. Орныхоо ялгамжааг магадлахад хамаарахгүй төрөхийн тул хэмээвээс. Орныхоо ялгамжааг магадлахад хамаарахгүй сэжгийн мэдэл мөн чанараар буй бус. Тэр адилаар урьд буй хийгээд үгүй ямагт хэмээн хорьчихсон тул. Дөрөвдүгээрх, хэрэгт шинжлэхүйд хоёр болой. Бодит хийгээд гэм тэвчсэнийг хаах болой. Анхдугаарх нь, хэрэг тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, хэргийн утга алинд магадлахыг эс татахад сэжиг орсноор хэрэг мөн чанараар бүтэхийн тул. Сэжиг ч мөн чанараар буй болой, хэмээвээс. Хэргийн утгад бумбын утгыг чухалчилваас, бум-

477. -ба мөн чанараар бүтсэнийг бүтээхийн тул шавар тэргүүтэнд орох бус болой. Бумба буйн шаварт бумбыг бүтээхийн тулд орох хэрэггүй. Бумба үгүйн шаварт бумба мөн чанараар бүтсэнийг бүтээхийн тулд орох ч утга үгүйн тул болой. Хоёрдугаарх нь, бус тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, бумбыг чухалчилсан хүн шаварт орно, элсэнд орох бус. Цэмбэ чухалчилсан хүн утсанд орно, дэрсэнд орох бусын үлгэр буйн тул хэмээвээс. Тэр үлгэр мэт ч зохисгүй. Урьд зулыг хаасан лугаа адил мөний тул болой. Цэмбэ чухалчилсан хүн цэмбэ болчихсон утсыг цэмбэ бүтээхэд орох нь утгагүй. Цэмбэ болоогүй утсанд мөн чанараар бүтсэн цэмбийг бүтээхийн тул орох нь утгагүйн тул болой. Хэрэг мөн чанараар бүтсэн бус буюу. Хэрэг түүний эцэс мөн чанараар бүтсэнийг үзэх бус буюу. Түүний эхэн хийгээд дундах мөн чанараар бүтсэн нь үзэгдэхгүйн тул болой. Тавдугаарх үлгэр шинжлэхүйд хоёр болой. Бодит хийгээд гэм тэвчсэнийг хаах болой. Анхдугаарх нь, гал тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, ертөнц дахин хийгээд тогтсон таалалд оршсон бурхантан хийгээд Чавжүгва тэргүүтэн утга алинд ч оюунд зохилдохын утга түүнд зохилдуу үлгэрийг өгүүлснээс зохилдуу үлгэр мөн чанараар бүтсэний тул, үлгэр мөн

чанараар бүтсэн болой хэмээвээс. Гал нь галын үлгэр мөн учир ном зохилдуу ямагтын тул болой. Таалваас, гал нь галын сүр жавхлангийн үлгэр бус буюу. Тэр мэт болвоос үлгэр хийгээд үлгэртэнд хэтрэхийн тул болой. Усны сүр жавхлан ч гал түүний үлгэр бус болой. Ном үл зохилдуу тул болой. Хоёрдугаарх нь бус бас тэргүүлэх

478. болой. Утга нь, зарим нэгэн, хамагт ном зохилдсноор зохилдуу үлгэрийг өгүүлэх нь бус. Ашид үл зохилдохоор ч зохилдуу үлгэр өгүүлэх нь зохисгүй ч өчүүхэн ном зохилдуугаас зохилдуу үлгэр бүтсэн мөн хэмээвээс. Тэр ч бус буюу. Сүмбэр уул үс хоёр нь буй төдийд ном зохилдуу мөн ч зохилдуу үлгэр зохисгүйчлэн болой. Олонх ном зохилдуу нь зохилдуу үлгэр мөн болвоос сүмбэр уул хийгээд үс ч харилцан зохилдуу үлгэр болохын тул. Зургадугаарх, тогтсон тааллыг шинжлэхэд хоёр болой. Бодит хийгээд гэм тэвчсэнийг хаах болой. Анхдугаарх нь, эхлэл тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, чиний ёсонд ном алин үгүйн тул тогтсон таалал ч үгүй буюу. Тэр мэт болвоос тогтсон таалал мөн чанараар бүтсэн тул үлгэр мөн чанараар буй болой хэмээвээс. Тогтсон таалал мөн чанараар буй бус гэх нь, тогтсон таалал түүний эцэс мөн чанараар бүтсэн бусын тул буюу. Түүний эхэн мөн чанараар эс бүтсэн тул. Хоёрдугаарх нь, хэрэв тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, энэ төдийд тогтсон таалал энэ сэлтэс болой хэмээн мэдэхийн зааг мөн чанараар буй учир эхэн нь мөн чанараар буй болой хэмээвээс. Тогтсон таалал түүний эхэн бүтсэн болвоос дунд хийгээд эцэс мөн чанараар бүтсэн бус болой. Тэр мөн чанараар буй болвоос эхний цагт дунд хийгээд эцэс тэдгээр нүгүүд байх хэрэгтэй учир тэр үгүйн тул болой. Долдугаарх гишүүнийг шинжлэхэд хоёр болой. Бодит хийгээд түүний гэм тэвчсэнийг хаах болой. Анхдугаарх нь, гишүүн тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, чиний ёсонд бодит нь мөн чанараар үгүй учир түүнийг бүтээдэг таван гишүүнт бүтээх үг үгүй. Тэр үгүй бөгөөс бүтээгчийн үнэхээр учир шалтгаан ч үгүй болох болой. Тэр мэт болвоос бүтээгчийн гишүүн мөн чанараар бүтсэн буй хэмээвээс. Түүнийг хорих нь гишүүн мөн чанараар буй бус

479. буюу. Гишүүн нэжгээд нэжгээдэд хамаарсан гишүүнтэн мөн чанараар үгүйн тул. Зарим нэгэн, гишүүн нэжгээд нэжгээдэд хамаарсан гишүүнтэн тэр мэт үгүй ч гишүүн чуулахад гишүүнтэн мөн чанараар буй болой хэмээвээс. Гишүүний чуулганд ч гишүүнтэн мөн чанараар үгүй буюу. Гишүүн нэжгээд нэжгээдэд гишүүнтэн мөн чанараар үгүйн тул болой. Бус бас, гишүүн хийгээд гишүүнтэн хоёр мөн чанараар бүтвээс нэгд мөн чанараар буй юу, олонд мөн чанараар бүтэх үү. Анхдугаарх мэт болвоос таван гишүүнтүүд бүгд нэг ямагтад хэтрэх болох болой. Тэр гишүүнтэн лүгээ мөн чанараар бүтсэн нэг мөний тул. Хоёрдугаарх мэт болвоос, гишүүнтэн бүтсэнүүд тэр ч гишүүнд олон зургаад хэтрэх болох буюу. Бүтээх үгийн 5 гишүүнт бүтээх үг нь мөн чанараар бүтсэний тусгаар мөний тул болой. Гишүүнт мөн чанараар үгүй мөн буюу. Гишүүн нүгүүд урьд хожид гарах хийгээд хамт нэгэн гарахын гурван цаг алинд ч мөн чанараар эс бүтсэний тул болой. Хоёрдугаарх нь тийн бөгөөс тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, ороонго өвс нэжгээд нэжгээдээр зааныг хүлж чадахгүй ч олноор хурснаас хүлдэгчлэн гишүүний чуулганд гишүүнтэн мөн чанараар буй болой хэмээвээс. Тэр ч зохисгүй болой. Ороонго өвс олноор зааныг мөн чанараар хүлэх тэр ч үндсийг бүтээж үйлдэх лугаа адилын тул болой. Ороонго өвс олноор зааныг мөн чанараар хүлэх тэр ч зохисгүй буюу. Орон, цаг, хувьд нэрийдсэн олон ороонго өвс мөн чанараар чуулах буй хэмээн бүтээн үйлдэх ухаан үгүйн тул болой. Бус бас, бүтээх үгээр бүтээгдэхүүн бүтсэнийг

480. бүтээж байна уу, эс бүтсэнийг бүтээж байна уу. Анхдугаарх мэт гэвээс, гишүүнд дахин гишүүнийг бүтээн үйлдэхийн учир шалтгаан тусгаар нэгэн буйд хэтрэх буюу. Бүтээх үгээр бүтчихсэнийг бүтээхийн тул болой. Хоёрдугаарх мэт гэвээс, Ригважан чи бээр бүтээх үг түүгээр бүтээгдэхүүнийг бүтээхэд таалах нь зохисгүй буюу. Бүтээх үгээр эс бүтээгдсэн бүтээгдэхүүнийг мөн чанараар бүтээхийн тул болой. Зарим нэгэн, бүтээгдэхүүний гишүүн мөн чанараар буй болой. Бүтээгдэхүүнийг бүтээх учир шалтгаан мөн чанараар буйн тул хэмээвээс. Учир шалтгаан мөн чанараар буй бус буюу. Тангараглахаас учир шалтгаан мөн чанараар бүтсэний ангид хийгээд ангид бус нэгд байх бусын тул болой. Учир шалтгаанаар бүтээгдэхүүнийг мөн чанараар бүтээх нь эс бүтэх буюу. Тэр мөн бөгөөс учир шалтгаанд дахин бүтээн үйлдэгчийн учир шалтгаан байх хэрэгтэйгээс тэр үгүйн тул болой. Тэр бээр чухал найруулах хийгээд сүүл хураах нугууд мөн чанараар үгүй мөн буюу. Тангараглах хийгээд учир шалтгаан мөн чанараар үгүйн тул. Үлдэгдэл, үлгэр хийгээд чухал найруулах, сүүл хураах нугууд ч бүтээгдэхүүн бол бүтээн үйлдэгчийн учир шалтгаан үгүй болой. Чи өөрөө бүтээн үйлдсэн мөний тул. Хэрэв бүтээгдэхүүнийг бүтээх нь ганц учир шалтгаанаар үйлдэж байгаагаас учир шалтгаан нь өвөрчлөнгөөр буй болой хэмээвээс. Гэвч бүтээгдэхүүнийг бүтээхэд үлгэр авах утга үгүй болой. Учир шалтгаан ганцаар бүтээгдэхүүнийг бүтээхийн тул болой. Зарим нэгэн, ганц үгээр тангаргийг бүтээх мөн болой хэмээвээс. Бүтээгдэхүүнийг бүтээхэд учир шалтгаан утгагүй мөн болох уу. Ганц үлгэрээр бүтээхийн тул болой. Зарим нэгэн, учир шалтгаан биет бус хийгээд үлгэр огторгуйн эрдэм хоёроос эзэн

481. мөнх гэж бүтээдэг үлгэр хийгээд учир шалтгаан мөн чанараар бүтсэн болой хэмээвээс. Эзэн мөнх нь бүтсэн бус болой. Тэр үгүйн тул болой. Зарим нэгэн, бүтээх үгийн таван гишүүн чуулахад гишүүн хувь үгүй нэгэн болой. Түүгээр тангараг бүтэх болой хэмээвээс. Тэр мэт ч бус болой. Таван гишүүний алин нэгэнд гишүүн бусдыг нэгэнд шүтэхгүйн тул болой. Бусад үлгэрийг хэлэх цагт учир шалтгааныг өгүүлэхгүй хийгээд бусад учир шалтгааныг өгүүлэхийн цагт үлгэрийг өгүүлэхгүйн тул. Тангарагийн үгийн утга Бразиданя хэмээн өгүүлэхийн цагт урьд өгүүлэх үед хойт нь эс төрөх. Хойтыг өгүүлэх цагт урьдах нь хаагдахын тул. Тангарагийн үг ч мөн чанараар үгүй болой. Тэр өөрийн гишүүн үсгүүд ч мөн чанараар бүтэхгүй, бүтээх үгийн гишүүн мөн чанараар бүтэхийг хорих ухаан энэ мэт адилын тул. Наймдугаарх шинжлэлтэнийг шинжлэх нь сэжиг тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, шинжлэн ажиглахын цагт утгыг оносноор шинжлэлтэн мөн чанараар буй болой хэмээвээс. Шинжлэлтэн мөн чанараар бүтсэн бус болой. Сэжиг адил мөн чанараар үгүйн тул. Бүтчихсэний утгыг шинжлэлтэн шинжлэн орохгүй. Эс бүтсэний утга мөн чанараар бүтсэний тул шинжлэлтний шинжилгээ үл орохын тул. Есдүгээрх нотлон шийдэхийг шинжлэх. Эд тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, шинжлэн ажиглах цагт өгүүлэгдэхүүний утгыг нотлон шийдэж буйд нотлон шийдэх нь мөн чанараар буй болой хэмээвээс. Гишүүний эд хийгээд буй ямагт хэмээхийн ерөнхий утга тусгаар хийгээд нэг ямагт тэргүүтний тоолсон утга ангиуд нь нотлон шийдэх мөн чанараар үгүй буюу. Өөрийн гишүүн нүгүүд лүгээ мөн чанар

482. -аар бүтсэн ангид хийгээд ангид бус нэг хийгээд тэр хоёул бүтэх нь зохисгүйн тул. Аравдугаарх тэмцлийг шинжлэхэд хоёр болой. Бодит хийгээд түүний гэм тэвчсэнийг хаах болой. Анхдугаарх нь тэмцэл тэргүүлэх болой. Утга нь зарим нэгэн, төв үзэлтэн бээр өвөрмөц өгүүлэгч дор тэмцлийг бүтээснээр тэмцэл мөн чанараар буй болой хэмээвээс. Тэмцэл нь мөн чанараар буй бус болой. Тэмцлийг өгүүлэх дохио хийгээд өгүүлэгдэхүүн утгууд мөн чанараар үгүйн тул болой. Хоёрдугаарх нь, үнэмлэхүй тэргүүлэх болой. Утга

нь, зарим нэгэн, бумба хэмээхийн дохиог үйлдсэнээр бумбыг буй гэж мэдэхийн тул тэмцэл мөн чанараар буй болой хэмээвээс. Тэр зохисгүй болой. Бумба хэмээн өгүүлэх дохио хийгээд түүний өгүүлэгдэхүүн бумбууд үнэмлэхүйд үгүйн тул болой. Би бээр тэмцлийг хаасан нь үнэмлэхүйг шинжлэхийн шинжлэлийн үе мөний тул. Бус бас, ертөнц дахин өөрсдөө дохио үйлдсэний нэрүүд нь мөн чанараар бүтсэн бус буюу. Үнэхээр бусын чанх буруугаар утгыг буруудуулсан байдал олныг чи дахин дахин үзсэний тул. Үлгэрлэвээс, тэнгэр эх өгсөн хүнд тэнгэр өгсөн хэмээсэнчлэн ертөнцийн мэргэд бээр дохио үйлдсэнүүд ч мөн чанараар үгүй буюу. Өгүүлэгдэхүүний үг адил болой. Тэр хийгээд өгүүлэгдэхүүний утгад ч олон нэр утгад дохио учруулахыг үзэхийн тул. Үлгэрлэвээс, Гоу хэмээхийн дуу тэр эзэн хийгээд зүг тэргүүтэн утга есөд орох болой. Тиймээс тэмцэл мөн чанараар үгүй буюу. Өгүүлэгчийн тэмцлийн үг хийгээд өгүүлэгчийн тэмцлийн утгууд мөн чанараар бүтсэн нэгэн ямагт хийгээд түүний ангид ямагтад ч эс бүтсэний тул. Арваннэгдүгээрх өгүүлэх хийгээд арванхоёрдугаарх шүүн эсэргүүцэхийг шинжлэх. Өгүүлэх тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, өөрийн ёсыг өгүүлэх хийгээд бусдын ёсыг шүүх буйн тул тэмцэл өвөрчлөн-

483. -гөөр буй болой хэмээвээс. Тэмцлийн цагт өөрийн ёсны ухааныг өгүүлэх хийгээд бусдын ёсыг шүүн эсэргүүцэхэд тэмцэх, гэтлэх нүгүүд ч мөн чанараар үгүй буюу. Түүнд ч тэмцэл мөн чанараар бүтсэнийг хорих ухаан тэр адилын тул. Арвангуравдугаарх засдаг учир шалтгааныг шинжлэхэд хоёр болой. Бодит хийгээд гэм тэвчсэнийг хаах болой. Анхдугаарх нь учир шалтгаан тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, төв үзэлтэн бээр өгүүлэхийн учир шалтгаан бүгд засдаг учир шалтгаан учраас засдаг учир шалтгаан мөн чанараар буй болой хэмээвээс. Засдаг учир шалтгаан нь мөн чанараар үгүй болой. Учир шалтгаан өөрийн мөн чанар лугаа ном зохилдуу хийгээд ном үл зохилдууд мөн чанараар үгүйн тул. Учир шалтгаан өөрийн мөн чанар лугаа ном зохилдуу ямагтад мөн чанараар буй нь учир шалтгаанууд ч мөн болох хэрэгтэй. Тэр хийгээд учир шалтгаан ном үл зохилдууд мөн чанараар буй хэмээвэл засдаг учир шалтгаанд үзэхэд үзэгдэх ч үл зохихын тул. Тиймээс засдаг учир шалтгаан хэмээн өгүүлэх ч мөн чанараар буй бус буюу. Язгуурын мэдлээр огоот ажиглаваас тэр мэт үгүйн тул болой. Зарим нэгэн, засдаг учир шалтгаан мөн чанараар бүтсэн буюу. Түүний буруу зүг учир шалтгаан нугууд ч мөн чанараар бүтсэний тул хэмээвээс. Тэр зохисгүй бөгөөд учир шалтгаан нугууд ч мөн чанараар үгүйн тул буюу. Учир шалтгаан эс эндүүрэх нь эндүүрэх үгүй бөгөөд эндүүрэх лүгээ хагацсанд хамаарснаас агуулах мөн тул. Хоёрдугаарх нь эндүүрэх тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, эндүүрэх лүгээ сэлтийн учир шалтгаан мөн чанараар буй болой. Үлгэрлэвээс, хумхийн тоос мөнх бөгөөд биет бусын тул. Үлгэр нь, дараалчлан огторгуй хийгээд бумба адил

484. хэмээн хэлэхийн цагт шинж тэр зохих зүг, үл зохих зүг хоёулд мөн чанараар оршсоноор эндүүрэх лүгээ сэлтэст гэх бүтээгдэхүүнд эс эндүүрэх хэмээх нь: шинж тэр зохиолдох зүг, үл зохиолдох зүг хоёуланд мөн чанараар оршсоноор эндүүрэх лүгээ сэлтэс ухаан бус болой. Чи бээр учир шалтгаан биет бус хийгээд зохилдох зүг, үл зохилдох зүг тэдгээр нь мөн чанараар бүтсэн тусгаар мөнд таалахын тул болой. Бус бас, тэмцлийн суурийн дээр шүүх хийгээд бүтээгдэхүүнийг бүтээх хоёр нэгэн цагт чуулах тул. Тэмцлийн суурь тэдгээр нэгэн агшинтын тул болой. Зарим нэгэн, учир шалтгаан эс магадласан ямагтад эндүүрсэн лүгээ сэлтэст тавих хэрэгтэй. Мөн дор төв үзэлтэн чи бээр шүүх бүгдэд харш өгүүлэх мөн буюу. Учир шалтгаан эндүүрлийн бүтээгчийг өгүүлэх хийгээд шүүхийг өгүүлэх нь харшийн тул болой хэмээвээс. Тэр харш бус буюу. Цаг урд хийгээд хожид

тэдгээр дарааллаар гарснаар харш бусын тул. Зарим нэгэн, өнгөрсний засдаг учир шалтгаан бүтсэний тул. Эдүүгээгийн эндүүрэл лүгээ сэлтсийн засдаг учир шалтгаан мөн чанараар бүтсэн хэмээвээс. Тэр ч үл зохих буюу. Түгэн үйлдэгч гурван цаг мөн чанараар үгүйн тул. Бүтсэн гэвэл, бумба эвдэрсний хэлтэрхий нь тэр шавар хийгээд бумбын ирээдүй бус буюу. Түүний цагт өнгөрсний бумба хийгээд шавар нь өнгөрсөн үгүйн тул болой. Зарим нэгэн, гурван цаг мөн чанараар буй болой. Тэр үгүй бол өгүүлэгчийн тийн агуулга үгүйд хэтрэх болохын тул болой хэмээвээс. Өнгөрсөн учир шалтгаан эсвэл өнгөрсөн цаг нь мөн чанараар буй бус буюу. Язгуурын мэдлээр тийн ажиглаваас байхгүй байсны тул болой. Арван-

485. -дөрөвдүгээрх үгсийг ороохыг шинжлэх. Чи тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, төв үзлэтэн чи бээр шүүх бүгд башир хуурмагаар өдөөгдсөн бүхнээс буруу үгсийг ороосонд өгүүлсэн төдий мөний үнэмлэхүй нь бус тул үгсийг ороох мөн чанараар буй болой хэмээвээс. Төв үзлэтэн бээр шүүх нь хамаг үгсийг орооход өгүүлэх бус болой. Тэр мэт болвоос хариу бүгд үгсийг орооход хэтрэх болохын тул болой. Арвантавдугаарх хэтрүүлэхийг шинжлэх. Төрөх тэргүүлэх болой. Утга нь, бүтсэний утгад засдаг шүүхийг өгүүлдэг хэтрүүлэх буйгаар хэтрүүлэх мөн чанараар буй болой хэмээвээс. Хэтрүүлэх нь мөн чанараар үгүй болой. Шүүх нь төрөх хийгээд эс төрөх, төрж байгаачлан гурвуул хэтрүүлэх мөн чанараар буй бусын тул. Шүүх урьд хийгээд хожид нугууд мөн чанараар бүтсэн нэгэн ямагт хийгээд тусгаар ямагтад дахин өгүүлэх үгүйн тул болой. Арван зургадугаарх гэсгээхийг шинжлэх. Гэсгээх тэргүүлэх болой. Утга нь, бүтээгдэхүүнийг гэсгээхийн орон ч мөн чанараар үгүй болой. Түүнд хэтрүүлэхийг хорьсон ухаан тэр адил лугаа адилын тул болой. Гэсгээж дууссаны орныг дахин гэсгээх үгүй буюу. Түүнд хэрэг үгүйн тул болой. Үлгэрлэвээс, хүлэгдсэн хүнийг хүлэхийн адил болой. Гуравдугаарх хаахад тэмцлийг тэвчих. Хоёул тэргүүлэх болой. Утга нь, зарим нэгэн, чиний ёсонд шалгадаг мэдэл тэргүүтэн шинжлэлтний үг утга арван зургаа мөн чанараар үгүй учир түүнийг хорих хаагч ч мөн чанараар үгүй. Тэр мэт болвоос хаагдахуун мөн чанараар бүтэхэд хэтрэх буюу. Тэгвэл хаах нь утгагүйд хэтэрсэн нэгэн болох болой хэмээвээс. Хаагдахуун мөн чанараар эс бүтвээс хаагч мөн чанараар эс бүтэх нэгэнд дуусах болой.

486. Хоёул мөн чанараар бүтсэнд ам авсны тул болой. Бус бас, өвөрмөц өгүүлэгч чи бээр надад бодит бүгдийг мөн чанараар үгүйд харшлахыг өгүүлж байгаа нь тэр зарим нэгэн адил би ч тэр мэт өгүүлэх мөн болой. Ерөнхий илтэд өгүүлэх бүгд нь мөн чанараар үгүйн тул болой. Тэр мэт бодит бүгд мөн чанараар хоосонд өгүүлсний зүгт өөр өөрийн нэрийдлийн суурьт шүтсэнээс нэрийдсэн төдий шалгадаг мэдэл тэргүүтний үг утга арванзургаагийн тийн агуулга бүгдэд болох хийгээд бодит нь мөн чанараар бүтсэнд барихын зүгт шинжлэлтний үг утга арванзургаагийн тийн агуулга бүгдэд үл болох. Зава Шэйраваас: алин дор хоосон ямагт болвоос түүн дор бүгд болох. Алин дор хоосон ямагт үл болвоос түүн дор бүгд үл болох хэмээн зарлигласан мэт болой. Ном үүний үг утга нь өөрийн тайлбар хийгээд эцэг хүүгийн төв үзлийн сайн номлол нугуудад зарлигласан эш язгуурын чимэг, хязгаарын шинжлэлийн цацрал лугаа сэлтэс агуу их дэлгэрвээс сайн хувьтын цагт үзэгдмүй. Эдүүгээ би бүрэн үйлдэх тэр адил гадаад дотоод хоёр хувьтаас эвлүүлэн жигдэлсэн бэрхэд одуулснаар дахин сайтар шинжлэгч нүгүүд бээр үгийн тайлбар энэ төдийгөөр ч зорьсон бөгөөд хэрэг энэ мэтийн үүднээс тэмцлийг хэлцэж найруулан туурвиснаар бурханы шашны гол аргыг барьж найруулан арвижуулж зохиосон болой. Гуравдугаарх төгсгөлийн утгад хоёр болой. Зохиолч хийгээд орчуулагч болой. Анхдугаарх

нь Нягтад тээрэмдэгч хэмээх судар. Хутагт багш Лүдүв бээр зохиосон болой хэмээсэн хийгээд хоёрдугаарх нь Хачийн

487. бандида Ананда хийгээд лозава гэлэн Дагжоршэйрав бээр орчуулсан болой. Жаранзургаан шүлэг болой хэмээсэн бөгөөд хоёулын утга нь уншсан төдийгөөр мэдэж чадах болой. Өгүүлбэл: Бурханы шашин дэлгэрэхийн цагт ухааны чуулганыг гийгүүлэгч бээр Боловсрон гэтлэхийн лянхуан цэцэрлэгийг дэлгэрүүлэх баяр хуримыг түгээвэй.

Цөвүүн цагийн урт өвлийн гамшиг тэр өнгөрсөн ч
Цөлх мэргэн ухаантнаа нирваны мөрийг гийгүүлсэнгүй ээ
Учир тиймийн тул ба бүрэн бидний
Улаан голыг самрах шалтгаанд одохоос эмээж
Учиртай хэдэн үгийг энд эвлүүлэн бичлээ.
Утга гүнзгий үгийг ухаарч буруу тайлсныг
Ухаант мэргэн төрөлхтнүүд уучилж бурууг залруулна уу
Тунамал өнгөт сэрүүн гэрэлт алиман сараар
Тэргүүлшгүй амьтны үйл нисванисын халуун тамыг сэрүүцүүлээд
Тэнцэшгүй ачит богд Зонховын шашны гумдайг цэцэглүүлэн
Тэр ямагтын сансар нирваны амгаланг хангах болтугай.
Төв үзлийн шастар “Нягтад тээрэмдэгчийн тайлбар, ухаарахуй ёст алтан хүрдэн”
хэмээх үүнийг би урьд зарлиг номыг хүртэж асан Чин сүжигтийн хийдэд хүрэх үед
Бандида ламын номон дотроос тасархай бутархай хагас тайлбар нэгийг олоод, тэр номыг
Чин сүжигт номон ханы зохиол юм болов уу гэж санаад, тэндэхийн лам нараас асуусанд
энэ номууд гарчигт байдаггүйг бид ч үзэж харсан гэсэн боловч мэргэдийн сайн номлол
мөн болох тул дээш татан авч сүнбүмийнх нь дотор оруулбаас сайн юмсан гээд, түүнийг
хуулж аваад, эх судрыг тэнд нь үлдээж хориод жил өнгөрсөн боловч хэл ирээгүй юм.
Гэтэл саяхан миний номон дотор хуудас нь тарж бутарсан тийм ном гарсанд урдахь хүсэл
бодлоо үр бүтээлтэй болгох тухайд өмнөх дутуу номууд дээр илүү дутууг нэмж гүйцээн
зохиож бичсэн болой. Шагжагийн тойн дүрт Жамъянжэйвишэйнэн бээр тэр ямагтад
тэргүүн өлмийгөө найруулаад, буруудаж ташаарсныг нэмэн бичиж гол номын тайлбарыг
тийн шинээр эмхтгэсэн болой. Үүгээр ч төрөл тутамдаа ялгуусны зарлигийн зохиол үйлс
зүг, цаг бүхнээ арвижан үйлдэх болтугай.

Сарва манга ла.